



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/203

Чингис хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.16, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 16 дугаар зүйлийн 16.8.6, 16.9.2, 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалтууд, Улсын Их Хурлын 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд үржүүлэгдэж буй баталгаажсан үүлдэр, омгийн мал болох Галшар сумын ноолуурын чиглэлийн "Галшарын Улаан" омгийн ямаа, хурд-уналга эдэлгээний чиглэлийн "Галшар" үүлдрийн адуу, Дадал сумын сүү-махны хосолмол ашиг шимтэй нутгийн үхэр сүрэгт үзлэг ангилалт хийж баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэн, ээмэгжүүлж бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай..

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Г.Гантөмөр	Хүнс, хөдөө, аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга
Гишүүд:	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга
	Н.Ган-Адъяа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Ундрах	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

2. Үзлэг ангилалт хийж баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэн ээмэгжүүлэн бүртгэлжүүлэх ажлыг технологийн хугацаанд хийж гүйцэтгэн тайлан мэдээг заагдсан хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Чогсомжав)-д, баталгаажсан үүлдэр, омгийн мал бүхий сумдад дэд ажлын хэсгийг томилон, хэрэгжилтийг ханган, тайлан мэдээг заасан хугацаанд ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт, сумдын Хөдөө аж ахуйн тасаг, Малын үржүүлэг технологийн нэгжүүдийн мал сүрэгт үзлэг ангилалт, ээмэгжүүлэлт хийх ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011306